



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 6721

Улаанбаатар хот

Н.Одонтуяаг ажилд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолыг тус тус ҮНДЭСЛЭН тушаах нь:

1. Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Нямсүрэнгийн Одонтуяаг 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн Цахим бүртгэл, зуучлал хариуцсан мэргэжилтнээр томилсугай.
2. Н.Одонтуяад байгууллагын архивын ажлыг хавсран гүйцэтгүүлсүгэй.
3. Н.Одонтуяагийн үндсэн цалинг ТЗ-5-3 ангилал зэрэглэлээр цалинжуулж, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 40 хувь, хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлийн хамт олгохыг нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.
4. Ажил үүргийн хуваарийг танилцуулахыг Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга /Г.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА



П.БАТХҮЛЭГ

1150500043